



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/560

Номгон


Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ковидын т
эмчилгээ үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, 11.1.4, 11.1.8, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийн 7.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын өрхийн эрүүл мэндийн төвүүд нь “Ковид-19” цар тахлын хүнд хэцүү цаг үед халдварын тархалтыг хумих, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвх санаачлагатай зохион байгуулан ажиллаж байгаа тул вакцинжуулалтын үйл ажиллагаа, гэрийн эргэлт, хамгаалах хувцас хэрэгсэлд шаардлагатай нэмэлт санхүүжилтыг олгосугай.

2.Оточмандал, Оточномгон, Энхбүрд, Наранмандал Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай байгаа 10.441.000 (Арван сая дөрвөн зуун дөчин нэгэн мянган) төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210301

Аймгийн Засаг даргын _____ оны _____ сарын _____
өдрийн А/560 дугаар захирамжийн хавсралт



ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН КОВИДЫН
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Тоо хэмжээ		Нийт зардал
Бензины зардал				
5	Оточ мандал	20x14=280 л	2200	616.000
6	Наранмандал	20x14=280 л	2200	616.000
7	Оточ номгон	20x14=280 л	2200	616.000
8	Энхбүрд	20x14=280 л	2200	616.000
Вакцинжуулалтын хоол				
9	Вакцинжуулалт	9x30=270	6500	1.755.000
Хамгаалал хувцас хэрэглэл				
10	Бээлий	5x30=150	35000	5.250.000
11	Халаад	9x30=270	3500	945.000
12	Малгай	9x30=270	100	27.000
13	Нийт зардал			10.441.000

_____оОо_____